

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БАЯНДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ӨМА-2026/100/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.Umnugovi@audit.mn</p> <p>Өмнөговь аймаг</p> <p>2026 он</p>	<p>Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Шижирболд Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn Аудитор: Т.Будсүрэн Утас: 70533552 Цахим хаяг: Budsurent@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3-4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	
2.1 Аудит хийсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан	6-7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8-9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10-11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11-12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13-14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл	14
3.5.1 Төсвийн төлөвлөлт	14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	14-16
3.5.3 Нэмэлт төсөв	16
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17-18
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	
5.1 Төлбөрийн акт	19-20
5.2 Албан шаардлага	20-22
5.3 Зөвлөмж	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	23-25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.02.25 № 222
танай _____ -ны № _____ -т

БАЯНДАЛАЙ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Т.ХИШИГБАТ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяндалай сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд 129,003.8 мянган төгрөгийн авлага, 82,764.9 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 8,708.0 мянган төгрөг зарцуулсан нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар букуу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.3.1, 20 дугаар зүйлийн 20.1 дэхь заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 249,994.0 мянган төгрөг, Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн хөрөнгө оруулалтаар 144,337.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил нийлүүгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал

байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2,207,770.8 мянган төгрөгийн 27 ажил, малын тоо толгойн албан татвараар 25.000.0 мянган төгрөгийн 16 ажлыг санхүүжүүлэн гэрээ байгуулан ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 2 зорилтын хүрээнд 8 арга хэмжээ, 103 заалтыг хэрэгжүүлэн 94.5 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	632,634,485.09	611,499,153.25
33	АВЛАГА	59,466,566.96	129,003,818.96
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	82,654,902.00
33500	Бусад авлага	59,466,566.96	46,348,916.96
33520	Хувь хүмүүсээс авах авлага	59,466,566.96	46,348,916.96
35	БАРАА МАТЕРИАЛ	573,167,918.13	482,495,334.29
35100	Түүхий эд материал	43,965,000.00	42,655,000.00
35110	Тусгай зориулалттай материал	43,965,000.00	42,655,000.00
35400	Хангамжийн материал	482,782,918.13	381,420,334.29
35410	Бичиг хэргийн материал	7,004,820.00	447,200.00
35420	Аж ахуйн материал	55,670,090.00	48,287,864.00
35430	Сэлбэг хэрэгсэл	49,499.90	-
35470	Бусад хангамжийн материал	420,058,508.23	332,685,270.29
35600	Мал амьтад	46,420,000.00	58,420,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	68,916,465,928.55	66,063,744,984.53
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	68,916,465,928.55	66,063,744,984.53
39200	Биет хөрөнгө	68,832,427,928.55	65,978,844,484.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,204,834,784.89	7,431,059,620.52
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,276,981,961.98)	(1,369,225,282.46)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	397,283,644.00	750,517,644.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	264,284,366.08)	(291,531,407.72)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	837,384,937.22	751,259,720.72
39206	Хуримтлагдсан элэгдэл	(441,019,979.45)	(348,969,330.13)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	593,745,481.00	613,539,056.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(316,092,241.22)	(346,672,860.45)
39209	Зам, гүүрийн байгууламж	70,786,658,404.02	70,795,058,404.02
39210	Хуримтлагдсан элэгдэл	(8,826,433,333.53)	(12,899,311,919.25)
39214	Бусад үндсэн хөрөнгө	191,897,200.00	993,302,253.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(54,564,640.32)	(100,181,413.72)
39300	Биет бус хөрөнгө	84,038,000.00	84,900,500.00
39301	Програм хангамж	3,132,500.00	2,270,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,132,500.00)	(1,407,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	84,038,000.00	84,038,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН =+	69,549,100,413.64	66,675,244,137.78
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	90,700,500.00	82,764,902.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	90,700,500.00	82,764,902.00
41300	Өглөг	90,700,500.00	82,764,902.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	110,000.00
41360	Бусад өглөг	90,700,500.00	82,654,902.00
41361	Байгууллагад төлөх өглөг	90,700,500.00	82,654,902.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	69,458,399,913.64	66,592,479,235.78
51	Засгийн газрын хувь оролцоо	69,458,399,913.64	66,592,479,235.78
51100	Засгийн газрын оруулсан капитал	844,020,134.69	844,020,134.69
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	844,020,134.69	844,020,134.69
51200	Хуримтлагдсан үр дүн	68,375,223,264.64	65,509,302,586.78
51210	Өмнөх үеийн үр дүн	70,698,704,117.94	68,375,223,264.64
51220	Тайлант үеийн үр дүн	(2,323,480,853.30)	(2,865,920,677.86)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	239,156,514.31	239,156,514.31
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	69,549,100,413.64	66,675,244,137.78

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	4,048,865,711.87	3,777,592,700.75
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,546,300,473.87	3,777,592,700.75
120	Нийтлэг татварын бус орлого	2,546,300,473.87	1,826,180,414.75
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,487,700.00	95,177,056.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,487,700.00	95,177,056.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	2,248,371,867.22	1,670,904,694.75
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	275,440,906.65	60,098,664.00
122	Тусламжийн орлого	-	1,951,412,286.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	1,951,412,286.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	1,670,775,557.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	1,670,775,557.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	280,636,729.00
122133	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	276,933,982.00
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,897,747.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	805,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,502,565,238.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	186,543,838.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	170,465,897.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,552,941.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	525,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,316,021,400.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,316,021,400.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,287,154,465.17	6,216,118,438.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,287,154,465.17	6,216,118,438.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,035,923,756.63	6,080,761,725.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	601,667,275.20	764,026,983.91
210101	Үндсэн цалин	214,173,856.51	246,752,506.61
210102	Нэмэгдэл	265,985,412.10	388,035,144.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,532,000.00	32,478,000.00
210104	Урамшуулал	90,402,388.51	96,761,333.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,573,618.08	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,254,927.78	99,942,585.62
210201	Тэтгэврийн даатгалын зардал	53,761,078.45	66,433,228.39
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	4,945,177.17	7,473,628.56
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	2,641,230.14	4,605,916.12
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	2,501,923.67	4,061,994.81
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	9,405,518.35	17,367,817.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,571,973.11	107,322,661.26
210301	Гэрэл, цахилгаан	6,803,101.31	16,784,341.46
210302	Түлш, халаалт	82,778,671.80	85,328,119.80
210303	Цэвэр, бохир ус	4,990,200.00	5,210,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	77,503,883.00	195,531,330.00
210401	Бичиг хэрэг	6,145,400.00	11,520,920.00
210402	Тээвэр, шатахуун	60,208,683.00	37,295,020.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,277,000.00	5,763,000.00

Өмнөговь аймгийн Баяндалай сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,788,600.00	139,385,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,084,200.00	1,567,390.00
2105	Нормативт зардал	-	200,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	77,666,384.10	23,756,449.90
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,144,534.10	-
210604	Урсгал засвар	51,521,850.00	23,756,449.90
2107	Томилолт, зочны зардал	19,360,000.00	9,300,000.00
210702	Дотоод албан томилолт	19,360,000.00	9,300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	516,823,129.00	93,254,485.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	516,823,129.00	93,254,485.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,575,076,184.44	4,787,427,229.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	62,018,000.00	165,832,031.94
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,305,000.00	2,082,503.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,505,753,184.44	4,619,512,694.77
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	251,230,708.54	135,356,713.21
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	116,897,548.21
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	116,897,548.21
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	116,897,548.21
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	116,447,548.21
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал\	-	450,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,690,483.00	18,459,165.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,180,750.00	8,748,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,146,688.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	35,363,045.00	9,711,165.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	201,540,225.54	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	201,015,840.59	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	524,384.95	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(2,238,288,753.30)	(2,438,525,737.86)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	85,192,100.00	427,394,940.00
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалтай хөрөнгийн зардал	85,192,100.00	427,394,940.00
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(85,192,100.00)	(427,394,940.00)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	(2,323,480,853.30)	(2,865,920,677.86)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,525,052,938.00	1,956,708,286.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,487,700.00	1,956,708,286.00
120	Нийтлэг татварын бус орлого	22,487,700.00	5,296,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,487,700.00	5,296,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,487,700.00	5,296,000.00
122	Тусламжийн орлого	-	1,951,412,286.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	1,951,412,286.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	1,670,775,557.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	1,670,775,557.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	280,636,729.00
122133	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	276,933,982.00
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,897,747.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	805,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,502,565,238.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	186,543,838.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	170,465,897.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,552,941.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	525,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,316,021,400.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,316,021,400.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,359,191,628.00	1,630,656,648.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,359,191,628.00	1,630,656,648.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,107,960,919.46	1,412,645,032.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	604,487,244.57	764,026,983.91
210101	Үндсэн цалин	216,993,825.88	246,752,506.61
210102	Нэмэгдэл	265,985,412.10	388,035,144.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,532,000.00	32,478,000.00
210104	Урамшуулал	90,402,388.51	96,761,333.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,573,618.08	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,254,927.78	99,942,585.62
210201	Тэтгэврийн даатгалын зардал	53,761,078.45	66,433,228.39
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	4,945,177.17	7,473,628.56
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	2,630,342.14	4,605,916.12
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	2,512,811.67	4,061,994.81
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	9,405,518.35	17,367,817.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,571,973.11	107,322,661.26
210301	Гэрэл, цахилгаан	6,803,101.31	16,784,341.46
210302	Түлш, халаалт	82,778,671.80	85,328,119.80
210303	Цэвэр, бохир ус	4,990,200.00	5,210,200.00

Өмнөговь аймгийн Баяндалай сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	75,215,083.00	189,833,785.00
210401	Бичиг хэрэг	4,646,600.00	4,821,800.00
210402	Тээвэр, шатахуун	59,418,683.00	37,095,915.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,277,000.00	5,653,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,788,600.00	139,385,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,084,200.00	2,878,070.00
2105	Нормативт зардал	-	200,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	54,826,850.00	24,225,450.00
210604	Урсгал засвар	54,826,850.00	24,225,450.00
2107	Томилолт, зочны зардал	19,360,000.00	9,300,000.00
210702	Дотоод албан томилолт	19,360,000.00	9,300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	117,873,491.00	164,859,078.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	117,873,491.00	164,859,078.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,371,350.00	52,934,489.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,006,500.00	50,851,986.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,364,850.00	2,082,503.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	251,230,708.54	218,011,615.21
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	199,552,450.21
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	199,552,450.21
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	199,552,450.21
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	116,447,548.21
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал\	-	83,104,902.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,690,483.00	18,459,165.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,180,750.00	8,748,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,146,688.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	35,363,045.00	9,711,165.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	201,540,225.54	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	201,015,840.59	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	524,384.95	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	165,861,310.00	326,051,638.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	165,861,310.00	326,051,638.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	165,861,310.00	326,051,638.00
2200	Дотоод эх үүсвэрээр	165,861,310.00	326,051,638.00
223001	Бусад хөрөнгө	165,861,310.00	325,341,638.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	710,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(165,861,310.00)	(326,051,638.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	844,020,134.69	239,156,514.31	70,897,263,826.20	71,980,440,475.20
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(198,559,708.26)	(198,559,708.26)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	844,020,134.69	239,156,514.31	70,698,704,117.94	71,781,880,766.94
4	Тайлант үеийн үр дүн	-	-	(2,323,480,853.30)	(2,323,480,853.30)
5	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	844,020,134.69	239,156,514.31	68,375,223,264.64	69,458,399,913.64
6	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	844,020,134.69	239,156,514.31	68,375,223,264.64	69,458,399,913.64
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	844,020,134.69	239,156,514.31	68,375,223,264.64	69,458,399,913.64
8	Тайлант үеийн үр дүн	-	-	(2,865,920,677.86)	(2,865,920,677.86)
9	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	844,020,134.69	239,156,514.31	65,509,302,586.78	66,592,479,235.78

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,000,215,900.00	1,559,624,008.79	440,591,891.21	77.97
12	Татварын бус орлого	2,000,215,900.00	1,559,624,008.79	440,591,891.21	77.97
120	Нийтлэг татварын бус орлого	100,000,000.00	5,296,000.00	94,704,000.00	5.30
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	100,000,000.00	5,296,000.00	94,704,000.00	5.30
122	Тусламжийн орлого	1,900,215,900.00	1,554,328,008.79	345,887,891.21	81.80
122005	Төсвөөс санхүүжих	1,900,215,900.00	1,554,328,008.79	345,887,891.21	81.80
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,000,215,900.00	1,559,624,008.79	440,591,891.21	77.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,750,215,900.00	1,309,630,008.79	440,585,891.21	74.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,712,354,100.00	1,298,144,508.79	414,209,591.21	75.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	787,565,500.00	687,471,782.91	100,093,717.09	87.29
210101	Үндсэн цалин	331,992,000.00	246,752,506.61	85,239,493.39	74.32
210102	Нэмэгдэл	388,838,000.00	388,035,144.30	802,855.70	99.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,478,000.00	32,478,000.00	-	100.00
210104	Урамшуулал	34,257,500.00	20,206,132.00	14,051,368.00	58.98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,733,200.00	90,695,860.62	10,037,339.38	90.04
210201	Тэтгэврийн даатгал	68,498,600.00	60,086,689.23	8,411,910.77	87.72
210202	Тэтгэмжийн даатгал	8,058,700.00	6,839,040.56	1,219,659.44	84.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,029,300.00	4,025,301.90	3,998.10	99.90
210204	Ажилгүйдлийн даатгал	4,029,300.00	3,839,824.00	189,476.00	95.30
210205	Эрүүл мэндийн даатгал	16,117,300.00	15,905,004.93	212,295.07	98.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	136,056,100.00	107,322,661.26	28,733,438.74	78.88
210301	Гэрэл, цахилгаан	23,988,800.00	16,784,341.46	7,204,458.54	69.97

Өмнөговь аймгийн Баяндалай сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210302	Түлш, халаалт	104,192,300.00	85,328,119.80	18,864,180.20	81.89
210303	Цэвэр, бохир ус	7,875,000.00	5,210,200.00	2,664,800.00	66.16
2104	Хангамж, бараа материалын зардал	229,412,100.00	188,349,706.00	41,062,394.00	82.10
210401	Бичиг хэрэг	7,737,500.00	4,821,800.00	2,915,700.00	62.32
210402	Тээвэр, шатахуун	37,521,400.00	35,701,836.00	1,819,564.00	95.15
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,993,800.00	5,563,000.00	430,800.00	92.81
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	164,172,100.00	139,385,000.00	24,787,100.00	84.90
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,987,300.00	2,878,070.00	11,109,230.00	20.58
2105	Нормативт зардал	230,000.00	200,000.00	30,000.00	86.96
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	230,000.00	200,000.00	30,000.00	86.96
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,360,000.00	24,225,450.00	134,550.00	99.45
210604	Урсгал засвар	24,360,000.00	24,225,450.00	134,550.00	99.45
2107	Томилолт, зочны зардал	14,387,500.00	8,960,000.00	5,427,500.00	62.28
210702	Дотоод албан томилолт	14,387,500.00	8,960,000.00	5,427,500.00	62.28
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	288,934,100.00	164,859,078.00	124,075,022.00	57.06
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	288,934,100.00	164,859,078.00	124,075,022.00	57.06
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	130,675,600.00	26,059,970.00	104,615,630.00	19.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	128,875,600.00	24,767,470.00	104,108,130.00	19.22
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,800,000.00	1,292,500.00	507,500.00	71.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,861,800.00	11,485,500.00	26,376,300.00	30.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,861,800.00	11,485,500.00	26,376,300.00	30.34
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,748,000.00	8,748,000.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,113,800.00	2,737,500.00	26,376,300.00	9.40
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	250,000,000.00	249,994,000.00	6,000.00	100.00
223001	Бусад хөрөнгө	250,000,000.00	249,994,000.00	6,000.00	100.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	44	42	2	95.45
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	4	4	-	100.00
610001	Төсвийн байгууллага	4	4	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	20	19	1	95.00
620001	Удирдах ажилтан	6	6	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	9	8	1	88.89
620003	Үйлчлэх ажилтан	4	4	-	100.00
620004	Гэрээт ажилтан	1	1	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	20	19	1	95.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	8	1	88.89
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	-	100.00
650010	Гэрээт ажилтан	1	1	-	100.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	5	5	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	280,636,729.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	280,636,729.00
122	Тусламжийн орлого	280,636,729.00
1221	Хандив тусламж /дотоод/	280,636,729.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	280,636,729.00
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	276,933,982.00
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,897,747.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	805,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	197,531,827.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	122,184,189.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	115,210,524.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	76,555,201.00
210104	Урамшуулал	76,555,201.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,246,725.00
210201	Тэтгэврийн даатгал	6,346,539.16
210202	Тэтгэмжийн даатгал	634,588.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	580,614.22
210204	Ажилгүйдлийн даатгал	222,170.81
210205	Эрүүл мэндийн даатгал	1,462,812.81
2104	Хангамж, бараа материалын зардал	1,484,079.00
210402	Тээвэр, шатахуун	1,394,079.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	90,000.00
2107	Томилолт, зочны зардал	340,000.00
210702	Дотоод албан томилолт	340,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,584,519.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,794,516.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	790,003.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,973,665.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,973,665.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,973,665.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	75,347,638.00
2200	Дотоод эх үүсвэрээр	75,347,638.00
223001	Бусад хөрөнгө	75,347,638.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	83,104,902.00
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(83,104,902.00)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(83,104,902.00)

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 460,171.4 мянган төгрөгийн алдаа⁸ илэрснээс аудитын явцад 460,171.4 мянган төгрөгийн алдааг залруулж ажилласан. Үүнд:

- Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан маягтаар 2025 оны Санхүүгийн тайланг тайлагнасан,
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг Үндсэн хөрөнгийн тайлангийн хуримтлагдсан элэгдлийн зардалтай тулган баталгаажуулахад 39,666.67 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Үндсэн хөрөнгийн тайлангийн тусламж хандиваар авсан дүнг Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн орлогын дүнтэй тулган баталгаажуулахад 95,887,056 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Мөнгөн гүйлгээний тайлангийн орон нутгийн төсвөөс санхүүжих орлогын дүнг Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн орон нутгийн төсвөөс санхүүжих дүнтэй тулган баталгаажуулахад 450,000 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн⁸
- Үр дүнгийн тайлан Үндсэн цалин /210101/ зардлыг 4,622,481.17 төгрөг, Тэтгэврийн даатгал /210201/ зардлыг 4,622,481.17 төгрөг, Бичиг хэрэг /210401/ зардлыг 931,503 төгрөг, Тээвэр, шатахуун /210402/ зардлыг 199,090 төгрөг, Шуудан холбоо, интернэтийн төлбөр /210403/ зардлыг 110,000 төгрөг, Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс /210406/ зардлыг 1,310,680 төгрөг, Урсгал засвар /210604/ зардлыг 2,905,450 төгрөг, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж /210801/ зардлыг 15,353,850 төгрөг, Бараа үйлчилгээний бусад зардал /210901/ зардлыг 57,976,652.94 төгрөг, Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх /210902/ зардлыг 790,003 төгрөг, Бусад урсгал шилжүүлэг /2132/ зардлыг 64,195,737 төгрөг, Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг /213405/ зардлыг 82,654,902 төгрөгөөр тус тус зөрүүтэй илэрхийлсэн,
- Санхүүгийн тодруулгын өглөгийн тайланд Цалингийн өглөгийг 8,122,955.07 төгрөг, НДШ-ийн өглөгийг 30,908,868.11 төгрөг, ХХОАТ-ийн өглөгийг 12,388,131.56 төгрөг, Тээвэр шатахууны өглөгийг 7,464,320 төгрөг, албан томилолтын өглөгийг 170,000 төгрөгөөр тус тус зөрүүтэй тусгасан,
- Тусгай зориулалтын шинж чанаргүй 55,950,000 төгрөгийн материалыг тусгай зориулалтын материалд бүртгэсэн,
- Өмнөговь аймгийн Засаг даргын 2025 оны А/1766 дугаар "Өвс тэжээлийн өрийг тэглэж, Мал хамгаалах сангийн өр, авлагыг бууруулах тухай" захирамжаар 7,821,650 төгрөг, Хувь хүнээс авсан 5,296,000 төгрөгийн авлагыг тус тус хаагаагүй байна.

Энэ нь УСНББОУС-1, "Санхүүгийн тайлангийн толилуулга", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аудитаар нийт 297,430.9 мянган төгрөгийн зөрчил⁷ илэрснээс 297,100.9 мянган төгрөгийн 5 зөрчилд давтан гаргахгүй байх албан шаардлага, 330.0 мянган төлбөрийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож ажилласан байна.

5.1 ТӨЛБӨРИЙН АКТ:

Илрүүлэлт: Тайлант онд албан хаагчдыг томилолтоор ажиллах үед хоолны хөнгөлөлт болох 230,000 төгрөгийг давхардуулан олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 14 дүгээр зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 6 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.2-д Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ: 2.2.1-д "унааны зардал", 2.2.2-д "байрны зардал", 2.2.3-д "хоолны зардал" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь : Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу төлбөрийн акт тогтоосон.

Илрүүлэлт: Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны А/31 дүгээр тушаалаар нэг удаагийн тэтгэмж урамшуулал олгохдоо хувь хүний орлогын албан татвар суутгаагүй байна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22.1-т "Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө", 22.1.1-т "хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж" Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дүгээр тушаалаар баталсан "Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх, албан татварын хөнгөлөлт эдлүүлэх журам"-ын 2.2-т "Суутган төлөгч нь хууль тогтоомжид тусгайлан заагаагүй "Хөдөлмөрийн дотоод журам" зэрэг зөвхөн тухайн байгууллагын баримт бичиг, шийдвэрийг үндэслэн олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламжийг албан татвараас чөлөөлөхгүй" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь : Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу төлбөрийн акт тогтоох

5.2 АЛБАН ШААРДЛАГА:

Илрүүлэлт: Тайлант онд Өвсний 81,200,000 төгрөг, Зохиогчийн хяналтын 1,454,902 төгрөг, Хувь хүнээс авах өвсний 46,348,916.96 төгрөгийн авлагатай тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах" гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3 "Хууль тогтоож, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасны дагуу албан шаардлага хүргүүлэх

Илрүүлэлт: Өвс тэжээлийн байгууллагад төлөх 81,200,000 төгрөг, Зохиогчийн хяналтын 1,454,902 төгрөг, Шуудан холбооны 110,000 төгрөгийн өр төлбөртэй тайлагнасан байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах" гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, төсвийг зохистой удирдаж өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх

Илрүүлэлт: Сумын Засаг Даргын 2025 оны А/197 дугаар захирамжаар Баяндалайн хөгжил шинэчлэл-2028 хөтөлбөрийн хүрээнд хүүхэд, залуучуудын оролцоог хангах сургалтын зардалд 2,708,000 төгрөг, 2025 оны А/102 дугаар захирамжаар "Эрдэнэцогт хайрхан"-ыг тахиж зардалд 5,000,000 төгрөг, 2025 оны А/153 дугаар захирамжаар "Сайхан сарлаг 2025" арга хэмжээний зардалд 1,000,000 төгрөг, нийт 8,708,000 төгрөгийн анхан шатны баримтын иж бүрдэл дутуу, нэхэмжлэхийг бөөн дүнгээр шивсэн, зарцуулалтын тайлан байхгүй байна

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14 дүгээр зүйлийн 14.3.1-т "анхан шатны баримт бүрдүүлэх", 20 дугаар зүйлийн 20.1-т "Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй байх бөгөөд дараах бүрэн эрхтэй байна"

Шийдвэрлэсэн: Ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог үндэслэн түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн ажилтны гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулж ажиллах албан шаардлага хүргүүлэх

Илрүүлэлт: Сумын Засаг даргын 2025 оны А/198 дугаар захирамжаар ЗДТГ-ын дарга, Сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны Б/42 дугаар тушаалаар санхүү албаны дарга нарт ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй шалтгаанаар ээлжийн амралтын цалинг 1.5 хувиар нэмэгдүүлэн тооцож цалингийн сангаас 5,101,500 төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", ЗДТГ-ын даргын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/02 дугаар тушаалаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын Долоо. Ажлын цаг ашиглалт, 7.9-т "Ажил тасалсан, хожимдсон хүний ажиллаагүй цаг өдөрт ноогдох хөлсийг нь цалингаас хасаж тооцно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажлын зайлшгүй шаардлага гэдэгт байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой мэдлэг, мэргэжил, ур чадвар, эсвэл гэнэтийн нөхцөл байдлаас үүдэн ажилтныг ээлжийн амралтгүй ажиллуулах, өөр ажилд шилжүүлэх зэрэг хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг өөрчлөх албан ёсны хэрэгцээг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлэх

Илрүүлэлт: Шатахууны зарцуулалтыг түүвэрлэн шалгахад жолоочийн тооцооны хуудас байхгүй, спидометрийн заалт бичээгүй, шаардах хуудас бөглөөгүй, шатахууны норм, норматив тооцоогүй, мөн хувийн эзэмшлийн суудлын автомашинд шатахууныг хяналтгүй зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, баг, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар "Жишиг норм батлах тухай" тушаалын 1 дүгээр хавсралт, 2 дугаар хавсралт, 3 дугаар хавсралт-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь Анхан шатны баримтыг бүрдүүлж, жолоочийн тооцооны хуудсыг үнэн зөв хөтөлж, шатахууны тооцоо бодох, түлш шатахууныг нормоор зарцуулах зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

5.3 ЗӨВЛӨМЖ:

Зөвлөмж өгөгдөөгүй байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан маягаар 2025 оны Санхүүгийн тайланг тайлагнасан	1	0			1	0	1	0				
Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг Үндсэн хөрөнгийн тайлангийн хуримтлагдсан элэгдлийн зардалтай тулган баталгаажуулахад 39,666.67 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн	1	39.6			1	39.6	1	39.6				
Үндсэн хөрөнгийн тайлангийн тусламж хандиваар авсан дүнг Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн орлогын дүнтэй тулган баталгаажуулахад 95,887,056 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн	1	95,887.0			1	95,887.0	1	95,887.0				
Мөнгөн гүйлгээний тайлангийн орон нутгийн төсвөөс санхүүжих орлогын дүнг Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн орон нутгийн төсвөөс санхүүжих дүнтэй тулган баталгаажуулахад 450,000 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн	1	450.0			1	450.0	1	450.0				
Үр дүнгийн тайлан Үндсэн цалин /210101/ зардлыг 4,622,481.17 төгрөг, Тэвгэврийн даатгал /210201/ зардлыг 4,622,481.17 төгрөг, Бичиг хэрэг /210401/ зардлыг 931,503 төгрөг, Тээвэр, шатахуун /210402/ зардлыг 199,090 төгрөг, Шуудан холбоо, интернэтийн төлбөр /210403/ зардлыг 110,000 төгрөг, Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс /210406/ зардлыг 1,310,680 төгрөг, Урсгал засвар /210604/ зардлыг 2,905,450 төгрөг, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж /210801/ зардлыг 15,353,850 төгрөг, Бараа үйлчилгээний бусад зардал /210901/ зардлыг 57,976,652.94 төгрөг, Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх /210902/ зардлыг	1	235,672.8			1	235,672.8	1	235,672.8				

Өмнөговь аймгийн Баяндалай сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

790,003 төгрөг, Бусад урсгал шилжүүлэг /2132/ зардлыг 64,195,737 төгрөг, Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг /213405/ зардлыг 82,654,902 төгрөгөөр тус тус зөрүүтэй илэрхийлсэн												
Санхүүгийн тодруулгын өглөгийн тайланд Цалингийн өглөгийг 8,122,955.07 төгрөг, НДШ-ийн өглөгийг 30,908,868.11 төгрөг, ХХОАТ-ийн өглөгийг 12,388,131.56 төгрөг, Тээвэр шатахууны өглөгийг 7,464,320 төгрөг, албан томилолтын өглөгийг 170,000 төгрөгөөр тус тус зөрүүтэй тусгасан	1	59,054.2			1	59,054.2	1	59,054.2				
Өмнөговь аймгийн Засаг даргын 2025 оны А/1766 дугаар "Өвс тэжээлийн өрийг тэглэж, Мал хамгаалах сангийн өр, авлагыг бууруулах тухай" захирамжаар 7,821,650 төгрөг, Хувь хүнээс авсан 5,296,000 төгрөгийн авлагыг хаагаагүй	1	13,117.6			1	13,117.6	1	13,117.6				
Тусгай зориулалтын шинж чанаргүй 55,950,000 төгрөгийн материалыг тусгай зориулалтын материалд бүртгэсэн	1	59,950.0			1	59,950.0	1	59,950.0				
Дүн	8	460,171.4			8	460,171.4	8	460,171.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	А/т/тоо	Тоо	Дүн
Тайлант онд Өвсний 81,200,000 төгрөг, Зохиогчийн хяналтын 1,454,902 төгрөг, Хувь хүнээс авах өвсний 46,348,916.96 төгрөгийн авлагатай тайлагнасан	1	129,003.8			1	129,003.8						
Өвс тэжээлийн байгууллагад төлөх 81,200,000 төгрөг, Зохиогчийн хяналтын 1,454,902 төгрөг, Шуудан холбооны 110,000 төгрөгийн өр төлбөртэй тайлагнасан	1	82,764.9			1	82,764.9						
Сумын Засаг Даргын 2025 оны А/197 дугаар захирамжаар Баяндалайн хөгжил шинэчлэл-2028 хөтөлбөрийн хүрээнд хүүхэд, залуучуудын оролцоог хангах сургалтын зардалд 2,708,000 төгрөг, 2025 оны А/102 дугаар захирамжаар "Эрдэнэцогт хайрхан"-ыг тахиx зардалд 5,000,000 төгрөг, 2025 оны А/153 дугаар захирамжаар "Сайхан сарлаг 2025" арга хэмжээний зардалд 1,000,000 төгрөг, нийт 8,708,000 төгрөгийн анхан шатны баримтын иж бүрдэл дутуу, нэхэмжлэхийг бөөн дүнгээр шивсэн, зарцуулалтын тайлан байхгүй	1	8,708.0			1	8,708.0						
Тайлант онд албан хаагчдыг томилолтоор ажиллах үед хоолны хөнгөлөлт болох 230,000 төгрөгийг давхардуулан олгосон	1	230.0	1	230.0								
Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны А/31 дүгээр тушаалаар нэг удаагийн тэтгэмж урамшуулал олгохдоо хувь хүний орлогын албан татвар суутгаагүй	1	100.0	1	100.0								
Сумын Засаг даргын 2025 оны А/198 дугаар захирамжаар ЗДТГ-ын дарга, Сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны Б/42 дугаар тушаалаар санхүү албаны дарга нарт ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй шалтгаанаар	1	5,101.5			1	5,101.5						

ээлжийн амралтын цалинг 1.5 хувиар нэмэгдүүлэн тооцож цалингийн сангаас 5,101,500 төгрөгийг олгосон												
Шатахууны зарцуулалтыг түүвэрлэн шалгахад жолоочийн тооцооны хуудас байхгүй, спидометрийн заалт бичээгүй, шаардах хуудас бөглөөгүй, шатахууны норм, норматив тооцоогүй, мөн хувийн эзэмшлийн суудлын автомашинд шатахууныг хяналтгүй зарцуулсан	1	71,522.7			1	71,522.7						
ДҮН	7	297,430.9	2	330.0	5	297,100.9						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны хуультай холбоотой зөрчил гараагүй байна.								
Дүн								
Бусад хууль, тогтоомжтой холбоотой зөрчил								
Бусад хууль, тогтоомжтой холбоотой зөрчил гараагүй байна.								
Дүн								